

UCS 1701A:2022

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ




Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах,  
тээвэрлэх арга зүйн менежмент



# ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах,  
тээвэрлэх арга зүйн менежмент

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 25-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	4
2. Норматив эшлэл .....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт .....	5
4. Хог хаягдлыг ангилан ялгах тэмдэглэгээ .....	6
5. Хог хаягдал цуглуулах саванд тавих ерөнхий шаардлага .....	7
6. Хогны савны загвар, төрөл .....	9
7. Хог хаягдал цуглуулах, хадгалах талбайн сонголт .....	14
8. Хог хаягдал ангилах зай талбайн шаардлага .....	15
9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй .....	15
10. Ангилсан хогийг тээвэрлэх заавар .....	18
Хавсралт 1 .....	20
Хавсралт 2 .....	21
Ашигласан материалын жагсаалт .....	23

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хуванцар, гялгар уут /Үндсэн тэмдэг/ .....	7
Зураг 2. Хуванцар, гялгар уут /Туслах тэмдэг/ .....	7
Зураг 3. Шил, лааз /Үндсэн тэмдэг/ .....	7
Зураг 4. Шил, лааз /Туслах тэмдэг/ .....	7
Зураг 5. Цаас /Үндсэн тэмдэг/ .....	7
Зураг 6. Цаас /Туслах тэмдэг/ .....	7
Зураг 7. Хүнс /Үндсэн тэмдэг/ .....	7
Зураг 8. Хүнс /Туслах тэмдэг/ .....	7
Зураг 9. Бусад хог /Үндсэн тэмдэг/ .....	7
Зураг 10. Бусад хог /Туслах тэмдэг/ .....	7
Зураг 11. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав .....	9
Зураг 12. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав /жишээ зураг/ .....	10
Зураг 13. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав /жишээ зураг/ .....	11
Зураг 14. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав /жишээ зураг/ .....	12
Зураг 15. Хоёр төрлөөр хог ангилах савны жишээ .....	13
Зураг 16. Хог ачих цэгийн талбайн зураг .....	14
Зураг 17. Галын хор, конус хувин .....	16
Зураг 18. Гал мэдрэгч бөмбөлөг /Галыг мэдрэн богино хугацаанд задарч унтраана/ .....	16
Зураг 19. Хог түр хадгалах савыг ариутгах .....	17
Зураг 20. Шахагчтай тээврийн хэрэгсэл .....	18
Зураг 21. Битүү тэвштэй тээврийн хэрэгсэл .....	19

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хог хаягдлыг ангилан ялгах төрлийн өнгөний код .....	6
Хүснэгт 2. Хог хаягдлыг ангилан ялгах таних тэмдэг .....	7
Хүснэгт 3. Эрх зүйн баримт бичгийн жагсаалт .....	20
Хүснэгт 4. Сав баглаа боодлын материалын товчлол ба дугаарлалт .....	21



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Г Хог хаягдлын менежментэд хамаарах хотын стандартыг батлах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.1</sup> дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Хог хаягдлын менежмент бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

- 1.1. UCS1703A:2022 “Аюултай хог хаягдлын менежмент” хотын стандарт
- 1.2. UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт
- 1.3. UCS 1706A:2022 “Барилгын хог хаягдлын менежмент” хотын стандарт
- 1.4. UCS1704A:2022 “Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны менежмент” хотын стандарт
- 1.5. UCS1705A:2022 “Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100325



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 25  
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

### UCS 1701A:2022 “ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, АНГИЛАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ АРГА ЗҮЙН МЕНЕЖМЕНТ” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Хог хаягдлын тухай хууль;
- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам;
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Хот байгуулалтын тухай хууль;
- Ногоон хөгжлийн үзэл баримтлал, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах журам;
- MNS 5566:2005 Аж ахуй нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага;
- MNS:5344 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS ISO 3833:2010 Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 6593:2016 Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 4978:2000 Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
- MNS 4643: 1998 Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө;
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм дүрэм;
- БНБД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл;
- БНБД 22-01-01 Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм.

### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Төвлөрсөн хогийн цэг** – гэж айл өрх, аж ахуй нэгж байгууллагаас тээвэрлэгдэн ирсэн хог хаягдлыг ландфилл технологийн дагуу дарж булдаг тусгай зөвшөөрөгдсөн талбай;

**Хог хаягдал** - гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материал;

**Хог хаягдал цуглуулах** - гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэх;

**Хог хаягдал хадгалах** - гэж байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулах;

**Хог хаягдал ангилах** - гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгах;

**Хог хаягдал хадгалах цэг** – гэж хог хаягдал цуглуулах зорилгоор байгуулсан зориулалтын сав, байгууламж;

**Хог хаягдал дахин боловсруулах** - гэж хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

**Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл** – гэж ахуйн хог хаягдлыг тээвэрлэх битүү чингэлэгтэй, ачааг ачихад нягтруулах, буулгахад өөрөө буулгах тусгай зориулалтын тоног төхөөрөмж бүхий тээврийн хэрэгсэл;

**Тээвэрлэгч** – гэж ахуйн хог хаягдлыг тээвэрлэх бүхий аж ахуйн нэгж, байгууллага иргэн;

**Тээвэрлүүлэгч** – гэж ахуйн хог хаягдлыг зориулалтын цэг, талбай, чингэлэг саванд цуглуулан тодорхой хугацаанд тээвэрлүүлж цэвэрлэх үүрэг бүхий айл өрх, иргэн, байгууллага, аж ахуйн нэгж;

**Дахивар** – гэж дахин боловсруулах хог хаягдал буюу шил, лааз, хуванцар, төмөр гэх мэт хоёрдогч түүхий эд;

**Шаарга** – гэж сайжруулсан, шахмал түлшнээс гарсан хаягдал;

**Хоёр дахь түүхий эд цуглуулах цэг** – гэж иргэд, аж ахуй нэгж байгууллага болон хог хаягдлын үйлчилгээний байгууллагаас дахин боловсруулагдах боломжтой хаягдлыг хүлээн авч ангилан төрөлжүүлж дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг бизнес эрхлэгчид;

**Хог хаягдлын бүтэц** – гэж хог хаягдлын төрөл, нийт хог хаягдалд төрөл тус бүрийн эзлэх хувь хэмжээ;

**Овор хэмжээ ихтэй хог хаягдал** - гэж 0.75 куб метрээс дээш эзлэхүүнтэй хог хаягдал;

**Эх үүсвэр** – гэж анхдагч хог үүсэж байгаа айл өрх, аж ахуй нэгж байгууллага, үйлдвэр;

**Хогийн савны тэмдэг** – гэж хогийн савны зориулалт, дахиврын төрөл, ангиллыг дүрс, өнгөөр ялгасан тэмдэг;

**Хог хаягдал цуглуулах цэг** – гэж хүний амьдрах орчин, үйл ажиллагаанаас үүссэн ахуйн хог хаягдлыг цуглуулан бөөгнүүлэх зориулалтаар тоноглож, төхөөрөмжлөгдсөн талбай, хашлага, зөвшөөрөгдсөн цэг;

**Байгаль орчинд ээлтэй технологи** – гэж уламжлалт технологитой харьцуулахад илүү сайжруулсан технологи бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө бага эсхүл бүр сөрөг нөлөөгүй технологи;

**Гэр хороолол** – гэж нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дахь инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдоогүй гэр орон сууц бүхий суурьшил;

**Орон сууц** – гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин;

**Аюултай хог хаягдал** – гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал;

**Анхааруулах тэмдэг** – гэж хор аюулын талаарх мэдээллийн хамгийн товч байдлаар дамжуулах график дүрслэл;

**Аюулын тэмдэглэгээ** – гэж тухайн аюултай хог хаягдлын хор аюулын шинж чанар, аюулын түвшинг илэрхийлсэн тэмдэглэгээ.

#### 4. ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ ТЭМДЭГЛЭГЭЭ

4.1. Аж ахуй нэгж байгууллага, орон сууц, гэр хорооллын айл өрхүүд хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаандаа энэхүү шаардлагад нийцсэн хог хаягдлын савыг ашиглана. Үүнд:

- 4.1.1. Хогийн савны ангилал;
- 4.1.2. Өнгөний шалгуур;
- 4.1.3. Загвар төрөл;
- 4.1.4. Байрлуулах талбайг сонгох;
- 4.1.5. Зай талбайн шаардлага;
- 4.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй.

4.2. Хогны савны ангилал болон өнгөний шалгуур үзүүлэлт. Орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын сав нь хамгийн багадаа дараах төрлөөр хог хаягдлыг ангилдаг байна<sup>1</sup>. Үүнд:

- 4.2.1. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал;
- 4.2.2. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал;
- 4.2.3. Хүнсний органик хог хаягдал.

*Хүснэгт 1. Хог хаягдлыг ангилан ялгах төрлийн өнгөний код*

№	Хог хаягдлын төрөл	Өнгө	Өнгөний код
1	Хуванцар, гялгар уут		C-84, M-11, Y-98, K-1
2	Хөнгөн цагаан лааз, металл, шил хаягдал		C-0, M-60, Y-100, K-0
3	Цаас		C-88, M-52, Y-0, K-0
4	Хүнсний органик хаягдал		C-42, M-68, Y-94, K-46
5	Бусад хог хаягдал		C-0, M-0, Y-0, K-85
6	Ахуйн аюултай хог хаягдал		C-2, M-0, Y-94, K-0











4.3. Хог хаягдлын төрлийг Хүснэгт 1-т тусгасан өнгөөр илэрхийлж, хогны саванд тэмдэглэгээг хийнэ.

4.4. Хог хаягдлыг ангилан ялгах таних тэмдгийг зөв ашиглах нь аливаа хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй бөгөөд зааварчилгааны тэмдгийг үндсэн болон нэмэлт тэмдэг гэж ангилна. Дараах хүснэгтэд хог ялгах таних тэмдгийн хэмжээг үзүүлэв.

<sup>1</sup> Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам



## Хүснэгт 2. Хог хаягдлыг ангилан ялгах таних тэмдэг

Үндсэн тэмдэг 340 мм х 240 мм	Туслах тэмдэг 570 мм х 200 мм
 <p data-bbox="236 493 691 521">Зураг 1.Хуванцар, гялгар уут (Жишээ зураг)</p>	 <p data-bbox="871 493 1326 521">Зураг 2.Хуванцар, гялгар уут (Жишээ зураг)</p>
 <p data-bbox="288 751 627 779">Зураг 3.Шил, лааз (Жишээ зураг)</p>	 <p data-bbox="930 751 1268 779">Зураг 4.Шил, лааз (Жишээ зураг)</p>
 <p data-bbox="320 995 606 1024">Зураг 5.Цаас (Жишээ зураг)</p>	 <p data-bbox="954 995 1240 1024">Зураг 6.Цаас (Жишээ зураг)</p>
 <p data-bbox="320 1229 606 1257">Зураг 7.Хүнс (Жишээ зураг)</p>	 <p data-bbox="943 1229 1224 1257">Зураг 8.Хүнс (Жишээ зураг)</p>
 <p data-bbox="300 1469 632 1498">Зураг 9.Бусад хог (Жишээ зураг)</p>	 <p data-bbox="919 1469 1267 1498">Зураг 10.Бусад хог (Жишээ зураг)</p>

**Тайлбар:** Энэхүү баримт бичигт дурдсан тэмдгийн төрлүүд нь олон улсын жишигт нийцсэн, олон удаагийн туршилт судалгаагаар батлагдсан болно.

## 5. ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ САВАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


5.1. Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах зөөврийн сав нь дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- 5.1.1. Хогийн сав нь бат бөх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, зэврэлтээс хамгаалагдсан байх;
- 5.1.2. Хогийн савны хог цуглуулах хэсгүүд нь дахивар хог хаях зориулалтыг заасан стандарт мэдээлэх тэмдэг, өнгөтэй байх;
- 5.1.3. Хогийн сав нь хог хаягдлыг ангилах, цуглуулах, ачих, тээвэрлэх технологид нийцсэн байх;

- 5.1.4. Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн таг эсхүл саравчтай байх;
  - 5.1.5. Түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байх;
  - 5.1.6. Хогийн савны металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалж энэхүү стандартад заасан өнгөөр, стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байх;
  - 5.1.7. Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлын савыг техникийн хяналтын төвүүдэд (жишээ нь: бойлерын өрөө эсхүл агааржуулалтын систем) байрлуулж болохгүй. Аливаа хий, ус эсхүл гүйдлийн тоолуур эсхүл бусад мэдрэмтгий хэрэгслийн гэмтлээс бүрэн хамгаалсан байх;
  - 5.1.8. Органик хог хаягдлын хувьд хангалттай агааржуулалтыг хийж байх шаардлагатай. Агааржуулалт нь цахилгаан эсхүл байгалийн хэлбэрээр байж болно. Агаар солилцооны харьцаа нь хамгийн багадаа  $0,8 \text{ м}^3/\text{ц}$  байна;
  - 5.1.9. Хогийн сав нь нарны шууд тусгал тусахаас сэргийлсэн саравч эсхүл сүүдэр газар байршсан байна.
- 5.2. Энгийн хог хаягдал болох ахуйн хог хаягдал, органик хог хаягдал, цаас, шил, хуванцар, лааз зэрэг дахивар хог хаягдлыг тухайн төрлийн заасан савнуудад цуглуулж тодорхой хугацаанд хадгална.
- 5.3. Органик хог хаягдал нь гадаргууг хуурах, зэв үүсгэх нөхцөл бүрдүүлдэг тул цайраар бүрсэн ган болон төмөр саванд хадгалж болохгүй. Цуглуулах савны дүүргэлт доорх байдлаар байвал тохиромжтой. Үүнд:
- 5.3.1. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар  $0,4\text{кг}/\text{дм}^3$  х нэрлэсэн хэмжээ (жишээ нь: 240 литр х 96кг);
  - 5.3.2. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар  $0,4\text{кг}/\text{дм}^3$  х нэрлэсэн хэмжээ, 1750 кг хүртэл;
  - 5.3.3. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар  $0,4\text{кг}/\text{дм}^3$  х нэрлэсэн хэмжээ, 2500 кг хүртэл.
- 5.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай шаардлага. Үүнд:
- 5.4.1. Хогны савны өндөр. Үйл ажиллагааны төхөөрөмж нь ашиглахад аюулгүй, энгийн байна. Хог хаягдлын савны өндрийг тусгай хэрэгцээт хүмүүс болон хүүхдүүдэд зориулж 85 см хүртэл болгон намсгах шаардлагатай. Үүнд хадгалах савны гишгэх хэсгийн газрыг намсгах эсхүл дээд тал нь 6% -ийн налуу замаар орц гарган тэргэнцэрт зориулсан замыг байгуулна;
  - 5.4.2. Нэвтрэх талбай. Хог хаягдлыг зайлуулах өрөө болон хог хаягдлын сав байршсан талбайд нэвтрэх хэсэг нь 150 см өргөнтэй, тэргэнцэр эргэх хангалттай зайтай байх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хогны сав нь бусад суурилуулсан хогны савнаас ялгасан тусгай тэмдэглэгээтэй байна.


## 6. ХОГНЫ САВНЫ ЗАГВАР, ТӨРӨЛ

- 6.1. Аж ахуй нэгж байгууллага, орон сууцны гадна талбайд байрлуулах хогны сав нь хамгийн багадаа доорх төрлөөр ангилж хадгална. Үүнд:
- 6.1.1. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал;
  - 6.1.2. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал;
  - 6.1.3. Хүнсний органик хог хаягдал гэсэн 3 төрлөөр.
- 6.2. Гэр хороололд байрлуулах хогны сав нь хамгийн багадаа дараах байдлаар ангилах шаардлагатай. Үүнд:
- 6.2.1. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал;
  - 6.2.2. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал;
  - 6.2.3. Хүнсний органик хог хаягдал;
  - 6.2.4. Үнс буюу шаарга.
- 6.3. Ангилал тус бүр нь таних тэмдэг, өнгөтэй байх бөгөөд гэр хорооллын айл өрхийн хашаанд бэхэлж суурилуулах зориулалттай хогны савны хувьд үнс, шааргийг галд тэсвэртэй материал бүхий саванд тусад нь ангилж хадгална.
- 6.4. Гадна талбайн ангилах хогийн савны шийдлүүд
- 6.4.1. Орон сууцны хороолол дунд тавих боломжтой хогны сав нь зурагт үзүүлсний дагуу байх нь тохиромжтой.



Зураг 11. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав (Жишээ зураг)

6.4.2. Нийтийн эзэмшлийн гудамж талбай болон орон сууцны хороолол дунд тавих боломжтой хогны сав нь Зурагт үзүүлсний дагуу байх нь тохиромжтой.




Зураг 12. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав (Жишээ зураг)

6.4.3. Ногоон бүсийн зуслан, амралтын газарт тавих хогны сав


Нүүрэн тал



Хажуу тал



Дээрээс харгдах байдал



Харагдах байдал



Зураг 13. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав (Жишээ зураг)


6.4.4. Нийтийн эзэмшил, аж ахуй нэгж байгууллагад байршуулах хогны савны шийдэл



Зураг 14. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав (Жишээ зураг)

Хэмжээ	Шийдэл	
Урт -3м Өндөр 1,5м Өргөн 1,5м	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний биеийн өндөрт тохирсон.</li> <li>• Савны амсрыг зөвхөн дахивар хийхээр тооцож хийсэн.</li> <li>• Ангилсан хаягдлыг ачихад хялбараар шийдэж дахивар бүрээр салж ачилт хийгдэнэ.</li> <li>• Хаягжилтыг цоолтуураар шийдсэн.</li> <li>• Шил ангилах хэсэг нь унаж хагарахаас сэргийлсэн, том жижиг хэмжээтэй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ус орохоос хамгаалж газраас хөндий.</li> <li>• Хоёр талаасаа дахивраа хийх шийдэлтэй.</li> <li>• Нараар цэнэглэгдэж хүн ойртохоор мэдэрч асдаг гэрэлтэй.</li> <li>• Савнуудыг холбосон салахгүй байх оньсон түгжээтэй.</li> <li>• Ангилан ялгах өнгийг шийдсэн.</li> </ul>

6.4.5. Гэр хорооллын хашаанд суурилуулах хогны савны шийдэл



Зураг 15. Хоёр төрлөөр хог ангилах сав (Жишээ зураг)

## 7. ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ ТАЛБАЙН СОНГОЛТ

7.1. Хог хаягдлыг үүсгэгч буюу оршин суугчид, иргэдийн амьдрах, ажиллах орчинд сөрөг нөлөөгүй, хог хаягдлаа хаяхад хялбар, цэвэрлэх, суллаж, ачиж тээвэрлэх технологид нийцсэн, хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байдлыг харгалзан үзэж хог хаягдал цуглуулах, хадгалах талбайн сонголтыг хийнэ.



Хог ачих тээвэрлэх технологид нийцсэн чихтэй сав

Хогийн сав байршуулах талбайн гадаргуу бетон эсвэл зориулалтын хавтан дэвсгэр дэвссэн байна.



Зураг 16. Хог ачих цэгийн талбайн зураг (Жишээ зураг)

7.2. Нэг хогны савны хэмжээ 100л дээш бол холбогдох байгууллагууд (орон нутгийн засаг захиргаа, аж ахуй нэгж байгууллагын удирдлага, сууц өмчлөгчдийн холбоо) дүүрэг, хороодын удирдлага болон хог хаягдлын үйлчилгээний байгууллагатай зөвшилцөж, тохиролцсоны дагуу хогны сав байршуулах талбайн сонголтыг шийднэ.

7.3. Хогийн сав байршуулах талбайн гадаргуу бетон эсхүл зориулалтын хавтан дэвсгэр дэвссэн байна.



- 7.4. Бүх хадгалах савны талбай, байршил нь хүрээлэн буй орчинтойгоо зохицсон хаалттай байна. Жишээ нь: Хана, хашаа, хаалт гэх мэт. Хог хаягдлыг цуглуулах савыг газар байршуулах боломжгүй тохиолдолд зорь болон бункерт байрлуулж болно.
- 7.5. Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах савны байршлыг бусдын эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй, үнэр, тоос шороо, чимээ шуугиан нь тухгүй байдал үүсгэхгүй байхаар зохицуулж сонгоно. Дараах шаардлагуудыг харгалзан үзэж талбайн сонголтыг хийнэ: Үүнд:
- 7.5.1. Орчны төлөвлөлтийн дагуу болон нийгмийн шаардлагаар бий болж байгаа олон нийтийн орон зай, амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх газар, үйлчилгээний төвүүдтэй харилцан уялдаатайгаар хогийн савыг байрлуулах;
- 7.5.2. Барилга байгууламж дотор аюултай бодис тархахаас сэргийлж шатан дээр байрлуулж болохгүй;
- 7.5.3. Хог хаягдлыг түр цуглуулж, хадгалах сав нь байшингийн хананаас хамгийн багадаа 4м-ийн зайтай байх ёстой (чийг үүсэхээс зайлсхийх, агаарын сэлгэлт хийх);
- 7.5.4. Агааржуулагчийн гаднаас агаар нэвтрүүлэх хоолойноос хамгийн багадаа 3 метрийн зайтай байх;
- 7.5.5. Хогийн савны тохиромжтой байрлал нь хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх машин орж, гарах, эргэлт хийх, ачихад саадгүй байх, эргэлтийн диаметр 22м талбайтай, гаднаас нэвтрэх боломжтой байна.


## **8. ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАХ ЗАЙ ТАЛБАЙН ШААРДЛАГА**

- 8.1. Суурилуулах талбайн хэмжээс: Талбайн хэмжээсийг савны хэмжээс, шаардагдах хамгийн бага зай, нэвтрэх талбай зэргийг харгалзан үзэж тодорхойлно.
- 8.2. Буулгах талбайн онцлог: Энэхүү талбайн хувьд хадгалах сав болон хаягдлын төхөөрөмжийн хооронд шат, нүх эсхүл бусад саад болох зүйл байхгүй байхаар зохион байгуулагдсан байх ёстой. Талбайн өндөржилт 6%-ийн налуугаас хэтэрч болохгүй.

## **9. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ**

- 9.1. Галын аюулаас сэргийлэх. Хогны сав байрлуулах талбай нь аврах гарцад саад учруулахгүй байршилд байх ба гал асаах эх үүсвэр бүхий өрөөнд байрлаж болохгүй. Гал түймрээс хамгаалах шаардлага нь барилга байгууламжийн галаас хамгаалах судалгаа, төлөвлөлт, зөвшөөрөл, орон нутгийн галаас хамгаалах аюулгүй байдлын холбогдох дүрэм, журам эсхүл галын байцаагчийн тодорхой шаардлагад үндэслэнэ.
- 9.2. Хэрэв 1100л-с дээш багтаамжтай савыг суурилуулах тохиолдолд гал унтраах хэрэгсэлтэй байна. (ААНБ, СӨХ-үүд гарт ойр газарт байршуулсан байна).
- 9.3. Галын аюулгүй байдлын үүднээс одоо ашиглаж байгаа хуванцар материалаар хийсэн хогны сав нь дүүргэх шаардлагыг зөв баримталж байгаа тохиолдолд ашиглах боломжтой.
- 9.4. Ялангуяа аюулгүй байдалтай холбоотой газарт (жишээлбэл эмнэлэг эсхүл ресторан) хог хаягдал (цаас, ашигласан сав баглаа боодол гэх мэт) цуглуулах савыг шатамхай бус материалаар хийсэн байх ба барилга байгууламжийн аюулгүй байдал бүрэн

хангагдсан байх ёстой. Ингэснээр гал түймэр гарах эрсдэл үүсэх тохиолдолд гал нь савнаас хальж цааш дамжих боломжгүй байхаар зохицуулна. Энэ зохицуулалтыг өөрөө гал унтраагчтай сав эсхүл автомат эсхүл чанга таглаатай савыг ашиглах замаар шийднэ.



*Зураг 17. Галын хор, конус хувин (Жишээ зураг)*



*Зураг 18. Гал мэдрэгч бөмбөлөг /Галыг мэдрэн богино хугацаанд задарч унтраана/  
(Жишээ зураг)*

- 9.5 Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх ажилтан нь өөрийн хөдөлмөр хамгааллыг хангах үүрэгтэй боловч холбогдох оператор (барилгын эзэн, түрээслэгч, аж ахуй нэгжийн байгууллагын удирдлага, оршин суугч иргэд гэх мэт) нь өөрийн чингэлэг, талбай, тээвэрлэх зам зэргийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.
- 9.6. Хэрэв хариуцагч өөрийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хог тээвэр үйлчилгээний компаниас өөрийн ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлээс хамгаалж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- 9.7. Хог хаягдлыг хогийн савнаас ачиж цуглуулах хүртэлх хугацаанд хогийн саванд буй бичил биетүүд нь таатай нөхцөлд үржиж, тархсаар байдаг. Эрүүл ахуйн асуудал болон эрүүл мэндийн эрсдэлээс зайлсхийхийн тулд дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:



Зураг 19. Хог түр хадгалах савыг ариутгах (Жишээ зураг)

- 9.7.1. Савны багтаамж нь сав дүүрч халихаас сэргийлэн хангалттай том байх шаардлагатай;
- 9.7.2. Сав нь хаагддаг тагтай байна;
- 9.7.3. Бохир савыг тогтмол цэвэрлэх шаардлагатай. Дулааны улиралд сард 2 удаа, хүйтний улиралд сард 1 удаа цэвэрлэж, ариутгал хийж байх;
- 9.7.4. Хог хаягдлын үйлчилгээний байгууллага нь хог хаягдлыг дүүрч, халихаас өмнө давтамж харгалзахгүй суллаж цэвэрлэх, аль болох ойр ойрхон хугацаанд хогыг ачиж цуглуулах хэрэгтэй. Хог хаягдлын тээвэрлэлтийг гэрээгээр зохицуулна. Урт хугацаанд сулладаг том савнаас илүү ойр ойрхон суллах шаардлагатай жижиг хэмжээний савыг байршуулах нь тохиромжтой;
- 9.7.5. Хогийн савыг үргэлж гадаа байршуулах шаардлагатай. Дотор суурилуулахаас өөр боломжгүй тохиолдолд суурилуулсан өрөөг хангалттай агааржуулалтаар хангана;
- 9.7.6. Нийтийн зориулалтай хогийн савыг орц, хонгил, шатан дээр суурилуулахыг хориглоно.

## 10. АНГИЛСАН ХОГИЙГ ТЭЭВЭРЛЭХ ЗААВАР

- 10.1. Техникийн бүрэн бүтэн байдал хангасан тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр ангилсан хаягдлыг тээвэрлэнэ.
- 10.2. Тээвэрлэгч тээврийн хэрэгсэл дээр ангилан ялгах хаягдлын таних тэмдгийг стандартад заасан байрлалд байрлуулсан байна.
- 10.3. Шахагчтай, задгай болон битүү тэвштэй гэсэн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл байна. Хэрэв задгай тэвштэй бол өөрөө буулгагч төхөөрөмжийг байршуулсан байна.



*Зураг 20. Шахагчтай тээврийн хэрэгсэл (Жишээ зураг)*

- 10.4. Хуваарийн дагуу хог ангилах цэгүүдээс ангилах төрлийн дагуу тээвэрлэлтийг хийнэ.
- 10.5. Ангилсан хогийг тээвэрлэх үйл ажиллагаанд тээврийн машин нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх ба нийслэлийн хог хаягдлын менежментийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим системд холбогдох боломжтой байна.
- 10.6. Ангилсан хог тээвэрлэх машин нь стандарт шаардлага хангаж тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байна.
- 10.7. Ангилсан хог тээвэрлэх зөвшөөрөл бүхий машин бүрд салоны болон урд, хойд талыг хардаг хар хайрцгийн камер, мэдрэгч суурилуулсан байна.
- 10.8. Ангилсан хогийг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч, ачигчийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцсаар хангасан байна.
- 10.9. Өвчтэй хэт ядарсан болон архи согтууруулах ундаа сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн жолооч, ачигчийг ажилд гаргахгүй байна.

Хог хаягдлыг халдваргүйжүүлэхэд хялбар, аюулгүй ачиж буулгахад тохиромжтой аюултай хог хаягдал зөөх тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлага хангасан битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгсэл нээлттэй тэвштэй, битүү бүхээгтэй, цистерн зэрэг тусгай зориулалтаар тоноглогдсон байна



Зураг 21. Битүү тэвштэй тээврийн хэрэгсэл (Жишээ зураг)

- 10.10. Цуглуулж тээвэрлэсэн ангилсан хаягдлын төрөл, эх үүсвэр, тоо хэмжээний талаар бүртгэл хөтөлж байх.
- 10.11. Нийтийн эдэлбэр газар, зам, талбайд байрлуулсан хогийн савны хог хаягдлыг хогийн сав дүүрч, халихаас өмнө давтамж харгалзахгүй суллаж тээвэрлэнэ.

**ХАВСРАЛТ 1.**

Дэлхийн зах зээл дээр дагаж мөрдөж байгаа олон улсын болон дотоодын холбогдох хэд хэдэн стандартуудыг оруулсан болно. Эдгээр баримт бичгүүд нь энэхүү сав баглаа боодлын гарын авлагын үндэс суурь болно.





*Хүснэгт 3. Эрх зүйн баримт бичгийн жагсаалт*





№	Улс/ байгууллага	Баримт бичгийн тайлбар	Огноо
1	ЕХ	Сав баглаа боодол, түүний хаягдлын зааварчилгаа (94/62/ЕС)	1994-12-20
2	ЕХ	Химийн бодисын бүртгэл, үнэлгээ, зөвшөөрөл болон хориглох журам (REACH) No 1907/2006	2006-12-18
3	ISO	"Хуванцар - Хуванцар бүтээгдэхүүний ерөнхий тодорхойлолт, тэмдэглэгээ" (ISO 11469)	2000-05-15
4	ISO	"Хуванцар - тэмдэглэгээ болон товчилсон нэр томъёо - 1-р хэсэг: Үндсэн полимер ба тэдгээрийн тусгай шинж чанарууд" (ISO 1043-1)	2001-12-15
5	ISO	"Хуванцар - тэмдэглэгээ болон товчилсон нэр томъёо - 2-р хэсэг: дүүргэгч ба бэхжүүлэгч материал (ISO 1043-2)	2000-07-15
6	ISO	"Хуванцар - тэмдэглэгээ болон товчилсон нэр томъёо - 3-р хэсэг: зөөлрүүлэгч" (ISO 1043-3)	1996-04-15
7	ISO	"Хуванцар - тэмдэглэгээ болон товчилсон нэр томъёо - 4-р хэсэг: Дөл сааруулагч" (ISO 1043-4)	1998-02-15
8	АНУ	"SPI резин тодорхойлох кодыг ашиглан зөв хэрэглэх зааварчилгаа" (Пластик үйлдвэрлэлийн холбоо)	1995-01
9	Хятад	"Электрон мэдээллийн бүтээгдэхүүний бохирдуулалтыг хянах тэмдэглэгээ" (SJ / T 11364-2006)	2006-11-06
10	Хятад	"Сав баглаа боодол дээрх дахин боловсруулах тэмдэглэгээний стандарт" (GB 18455-2001)	2001-09-18
11	Хятад	"Хуванцар сав баглаа боодлын бүтээгдэхүүнийг дахин боловсруулах тэмдэглэгээ" (GB / T 16288-1996)	1996-04-10
12	Япон	"Хуванцар сав, баглаа боодол болон цаасан сав, баглаа боодлын тухай хуулиар тогтоосон тэмдэглээ" (METI)	2002-03
13	Солонгос	EPR (үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага) – Ангилан ялгаж хаях тэмдэглэгээний систем (ENVICO)	2003-01-01
14	Герман	"Сав баглаа боодлын хог хаягдал үүсэхээс зайлсхийх, түүнийг дахин боловсруулах тухай захирамж" (дотоодын хууль)	1991-06-12
15	Герман	"Дахин боловсруулах сав баглаа боодлын материал, савлагааны тэмдэглэгээ; хуванцар сав баглаа боодлын материал болон савлагаа, график тэмдэг" (DIN 6120-1)	1996-12
16	Герман	"Дахин боловсруулах сав баглаа боодлын материал, савлагааны тэмдэглэгээ - хуванцар сав баглаа боодлын материал болон савлагаа Хэсэг 2: Нэмэлт тэмдэглэгээ (DIN 6120-2)	1996-12

**ХАВСРАЛТ 2.**

Олон улсын тэмдэг, тэмдэглэгээ түүний тайлбар, товчлол. Доорх хүснэгтэд сав баглаа боодлын материалын ангилал тус бүрд ашигладаг код, товчлолуудыг жагсаан харуулав.

*Хүснэгт 4. Сав баглаа боодлын материалын товчлол ба дугаарлалт*

Ангилал	Хамаарах тэмдэг	тайлбар	товчлол	дугаар
Хуванцар	(EX/Хятад тэмдэг)	Полиэтилен терефталат	PET	01
	 PET	Өндөр нягтралтай полиэтилен	HDPE	02
		Поливинил хлорид	PVC	03
		Бага нягттай полиэтилен	LDPE	04
		Полипропилен	PP	05
		Полистирол (Arcel™ орно)	PS	06
		Бусад (Полиуретан орно)	Бусад	07
(ISO тэмдэг) (Жишээ зураг)				
Хуванцар	>PET< ЗӨВХӨН зөөлөвч хөөсөнд:  (Жишээ зураг)	(Солонгос тэмдэг: бүх хуванцар материалын доод хэсэгт Солонгос үсэг байна)		
Цаас	(EX/Хятад тэмдэг)	Атираат картон хавтан	CFB	20
	 NCFB (ISO тэмдэг: байхгүй) (Жишээ зураг)	Атираат бус хатуу картон хавтан	NCFB	21
		Цаас	WPP	22
		Цаасан хавтан	PB	-
		Атираат хатуу цаас	CB	-
Ган	(EX/Хятад тэмдэг)	Ган	FE	40
	 FE (ISO тэмдэг: байхгүй) (Жишээ зураг)	Хөнгөн цагаан	ALU	41

Мод	(EX/Хятад тэмдэг)	Мод	NW	50
	 (ISO тэмдэг: байхгүй) (Жишээ зураг)	Үйс	FOR	51
Шил	(EX/Хятад тэмдэг)	Өнгөгүй шил	GL1	70
	 (ISO тэмдэг: байхгүй) (Жишээ зураг)	Ногоон шил	GL2	71
		Бор шил	GL3	72
Нэхмэл	(EX/Хятад тэмдэг)	Хөвөн даавуу	TEX	60
	 (ISO тэмдэг: байхгүй) (Жишээ зураг)	Сомронз даавуу	TEX	61
Холимог нэгдэл	(EX/Хятад тэмдэг)	Хуванцар / хөнгөн цагаан (ESD уут багтана)		11
	 (ISO тэмдэг: байхгүй) (Жишээ зураг)	Хуванцар / цагаан тугалга		12
		Хуванцар / холимог металлууд		13
		Хуванцар / шил		14
		Шил / хөнгөн цагаан		21
		Шил / цагаан тугалга		23
		Шил / холимог металл		23
		Цаас эсхүл картон хавтан / хуванцар		31
		Цаас эсхүл картон хавтан / Хөнгөн цагаан		32
		Цаас эсхүл картон хавтан / цагаан тугалга		33
		Цаас эсхүл картон хавтан / холимог металл		34
		Цаас эсхүл картон хавтан / хуванцар / металл		41

**Тэмдэглэл:** EX нь олон янзын материалыг кодоор ангилсан байдаг боловч хуванцраас бусад кодыг түгээмэл ашигладаггүй. Түүнчлэн, EX-ны код болон Хятад кодын хоорондоо зөрүүтэй тохиолдолд Хятад кодыг ашиглана.)



**АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

- Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2017 оны 5 дугаар сарын 12)
- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам 2020 оны 2 дугаар сарын 20 өдрийн НИТХ-ын тогтоол 32/03
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014 оны 9 дүгээр 18-ны МУ-ын ЗГ-ын 298 дугаар тогтоол )
- Б. Дэлгэрбаяр, Л.Жаргалсайхан хатуу хог хаягдлын менежмент 2019
- Б.Эрдэнэ, Д.Ичинхорлоо Хог хаягдлын менежмент гарын авлага 2018
- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого
- Байгаль орчны мэдээлэл, сурталчилгаа ба боловсрол төсөл, “ус” сэдвийн хүрээнд зохион явуулах ажлын арга зүйн боловсруулалт / сургуулийн өмнөх боловсрол /гарын авлага, монгол улс, 2010 он
- Changing behavior and making stick – environment and behavior, raimond de young
- Байгалын цогцолборт газарт амрагчдын зан үйлийг өөрчлөх судалгаа
- БОАЖЯ, “Environmental assessment report of Mongolia-2017-2018.” 2019.
- Environment Agency, “Waste Classification - Guidance on the classification and assessment of waste (Edition 1.1) Technical Guidance WM3







Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам  
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар